



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ"-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 8, 17 дугаар тогтоол, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн орон нутгийн өмчөөс шилжүүлсэн 4 нэрийн нийт 309,198,200.00 (гурван зуун есөн сая нэг зуун ерэн найман мянга хоёр зуун) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, хавсралтад заасны дагуу "Мэдээлэл, холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани (Говь-Алтай аймгийн салбар), "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанид тус тус эзэмшүүлж бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй..

2. Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Дашпунцаг, "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр, "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Т.Ганзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133001281



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны дугаар сарын 2-ний өдрийн  
дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ, БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д      | Хөрөнгийн нэр                                               | Ашиглалтанд<br>орсон он | Тоо<br>хэмжээ<br>(ш) | Нэг бүрийн үнэ | Балансын үнэ<br>(төгрөг)                                          | Хүлээн авч бүртгэх<br>байгууллага                                 |
|----------|-------------------------------------------------------------|-------------------------|----------------------|----------------|-------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------|
| 1        | 182 айлын орон сууцны<br>хорооллын холбооны шилэн<br>кабель | 2013                    | 1                    | 42,200,000.00  | 42,200,000.00                                                     | Мэдээлэл холбооны<br>сүлжээ ТӨХХК /Говь-<br>Алтай аймгийн салбар/ |
| 2        | Алтай хотын Гэр хорооллын 2<br>тарифт тоолуур               | 2020                    | 1600                 | 61,600.00      | 98,560,000.00                                                     |                                                                   |
| 3        | Алтай хотын Гэр хорооллын 2<br>тарифт тоолуур               | 2018                    | 1150                 | 77,375.00      | 88,981,250.00                                                     | Алтай-Улиастайн эрчим<br>хүчний систем ТӨХК                       |
| 4        | Алтай хотын Гэр хорооллын 2<br>тарифт тоолуур               | 2019                    | 1150                 | 69,093.00      | 79,456,950.00                                                     |                                                                   |
| Нийт дүн |                                                             |                         |                      |                | 309,198,200.00                                                    | -                                                                 |
|          |                                                             |                         |                      |                | (гурван зуун есөн сая<br>нэг зуун ерэн найман<br>мянга хоёр зуун) | -                                                                 |